ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** [Хүнсний бүтээгдэхүүн]

2. **Стандарт:**

Багц 1: **Мах махан бүтээгдэхүүн**

Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан махыг нийлүүлэгч нь өөрийн байр агуулахад нөөцөлж сар бүр сард авах хэмжээгээр нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, Хүнсний тухай хуульд заасан хүнсний аюулгүй байдлын зарчмыг хангасан, хадгалалтын хугацааг хянасан, мах нь чийг алдаагүй, хөлдөөсөн, гулууз гадаргуу цэвэр, гадны үнэр амтгүй 1- р зэргийн үхрийн байна. Нийт авах махны 70% нь үхрийн мах, 20% нь хонины мах, 10% нь ямааны мах байх шаардлагатай.

Тайлбар:Үхрийн мах нийлүүлэхдээ дайвар бүтээгдэхүүнийг дагалдуулан авна. Дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой, шийр орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй

Багц 2: **Сүүн сүүн бүтээгдэхүүн**

Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, ХТХ-д заасан хүнсний аюулгүй байдлын зарчмыг хангасан, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савлаж ирэх, гадны үнэр амтгүй , тослог зохих хэмжээнд шинэ сүү байна.

Аарц нь цагаан өнгөтэй, хэт исгэсэн биш, савласан болон хөлдүү, цэвэр саванд хадгалсан байна. Ааруул нь өтгөн сүүгээр бүрсэн тарагны ааруул байна

Ээсгий нь өтгөн сүүг ээдүүлж буцалгасан байна.

Цөцгий нь эсээгүй , буцалгасан шинэ байна.

Тараг нь исээгүй нэгэн жигд бүтэцтэй, хэт шингэн биш ариун цэврийн шаардлага хангасан уламжлалт аргаар бүрсэн байна.

Багц 3: **Хүнсний ногоо**

Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан монгол газрын хөрсөнд тариалагдсан монгол хүнсний ногоо байна. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан байна.

Төмс: Төмсний диаметр 6-7 см багагүй, нэг ширхэг төмс нь 120- гр аас дээш байх, гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хүйтний улиралд хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, механик хольцгүй, нэг тонн төмс бүрт 10 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний төмс нэмж нийлүүлэх

Байцай,ягаан байцаа: Байцай нь нягтрал сайтай муудаж гэмтээгүй, үнэр амтгүй, өт шавьжгүй элдэв механик хольцгүй байна.Дундаж жин 1,5 кг аас дээш байна.

Сонгино, сармис: ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй,ааг амт сайтай, гадны элдэв механик хольцгүй, соёолж хөгшрөөгүй, дундаж жин 100-150 гр байна.

Лууван: Механик хольцгүй, зөөлөрч муудаагүй, чийгээ алдаагүй, соёолоогүй

Өргөст хэмх, улаан лооль, манжин, чинжүү, бууцай, цэцэгт байцаа, хулуу, брокле,: Стандартын шаардлага хангасан гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй байна.

Тайлбар: Дарсан ногоо буюу лаазалсан , дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй.

Багц4: **Хуурай хүнс / Гадаад/**

Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савласан байна.

Гоймонгийн төрөл: Спагите, дун, хөндий, дүрс хэлбэрийн, нарийн савхан

Нийлүүлэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна. 0,4-5 кг-аар савлагдсан хуурай хөгцөрч муудаагүй, үйрч гэмтээгүй,хэлбэр дүрсээ алдаагүй шинэ байна. Өндөгний хольцтой урсамтгай биш чанартай байна.

Будааны төрөл: Цагаан, шар, хөц, гурвалжин, хүүхдийн будаа

MNS5411:2004 техникийн шаардлага хангасан байна. Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй шүдэнд мэдрэгдэх элсэрхэг хатуу зүйлгүй байна. Цагаан будаа том ширхэгтэй агшаахад няцрахгүй байна. / Сакура/

Элсэн чихэр:MNS5411:2004 техникийн шаардлага хангасан гадны механик хольцгүй ба үнэр амтгүй байна.

Бусад бараа бүтээгдэхүүн: эсгэгч, вариань, ургамлын тос, жигнэмэг, далай байцаа, амтлагч, жимс жимсгэнэ

Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Механик гэмтэлд ороогүй ,сав баглаа боодол гэмтээгүй, горимын дагуу хадгалагдсан, тунадас үүсээгүй өнгө үзэмж сайтай байна. Бүтээгдэхүүн савласан сав лааз баглааны гадна талд үйлдвэрлэгдсэн он, сар, өдөр харагдахуйц тод байх, хэрэглэх зааврыг дагалдуулж өгөх

Багц 5: **Хуурай хүнс / Дотоод/**

Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савласан байна.

Гурил, гурилан бүтээгдэхүүн: Эх орны үйлдвэрийн гурил, Хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичигтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирэх, хүнсний хуулийг хэрэгжүүлсэн, хадгалалтын хугацааг хянасан, зориулалтын саванд савласан байна.

Гурил: Үйлдвэрийн аргаар боловсруулагдсан, стандартын шаардлага хангасан, цагаан ба шаравтар цагаан туяатай, цагаан үнслэг багатай том ширхэгтэй байна. Зориулалтын MNS-2515:1994шаардлага хангасан, сав баглаанд савласан, хөгцөрч нороогүй, хадгалалтын хугацааг хянасан байх

Бусад бараа бүтээгдэхүүн: Давс, сод, эсгэгч,цай, вариань, зөгийн бал, жигнэмэг, жимс жимсгэнэ

Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Механик гэмтэлд ороогүй ,сав баглаа боодол гэмтээгүй, горимын дагуу хадгалагдсан, тунадас үүсээгүй өнгө үзэмж сайтай байна. Бүтээгдэхүүн савласан сав лааз баглааны гадна талд үйлдвэрлэгдсэн он, сар, өдөр харагдахуйц тод байх, хэрэглэх зааврыг дагалдуулж өгөх

3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэхдээ гарал үүслийн зөвшөөрлийн бичиг баримт худалдан, авсан тухай татварын төлбөрийн баримттай байх.]

4. **Бараа хүргэх газар:** [Баян-Адарга сумын Цэцэрлэгийн байр]

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь: Хавсралтаар**